



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/365

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5/a/, 29.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.2, 11.1.8, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн ээлжит III хуралдааны 01 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн VI хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдлийн менежмент” сэдэвт чанарын алба, багуудын гишүүдийг чадавхижуулах сургалт зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2.Шаардагдах зардал 496000/Дөрвөн зуун ерэн зургаан мянган/ төгрөгийг “Эрүүл мэндийн тогтолцооны дунд хугацааны стратеги”-ийг боловсруулан хэрэгжүүлэх зардал”-аас гаргахыг Санхүү төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.БАТЛУТ



Аймгийн Засаг даргын 2017 оны
06 дугаар сарын 28-ны өдрийн
#165 дугаар захирамжийн хоёрдугаар
хавсралт

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР,
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТ ТӨВИЙН
СУРГАЛТЫН ЗАРДЛЫН ТӨСӨВ**

№	Зардлын агуулга	Төсөвлөсөн (төг)	
		Зардлын задаргаа	Нийт дүн (төг)
1	Оролцогчдын цайны зардал	Цэвэр ус 60 хүн х 500 х 2өдөр	60000
		Печень 18,000 х 2	36000
2	Сургагч багш нарын унааны зардал	2 хүн х 50,000	100000
3	Багш нарын буудлын зардал	2 хүн х 50,000	100000
4	Хоолны зардал	2 хүн , 2 өдөр х 10,000 х 6	60000
5	Сургалтын хөлс	2 хүн	140000
Нийт дүн			496000